

АШИГТ МАЛТМАЛЫН
ГАЗАР



МӨНГӨ ОЛБОРЛОЛТ БА ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Ашигт малтмалын газрын
Уул уурхай, судалгааны хэлтэс



Судалгааны ажлыг удирдсан:

АМГ, УУСХ -ийн дарга

АМГ, УУСХ, СМСТ-ийн дарга

АМГ, УУСХ, СМСТ-ийн ахлах мэргэжилтэн

Ц.Даваацэрэн

А.Бямбадагва

Ц.Цэгц

Судалж гүйцэтгэсэн:

АМГ, УУСХ, СМСТ-ийн мэргэжилтэн

Ч.Навчаа

Судалгааны ажлын талаархи санал хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38, АМГ,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр, Баруун жигүүр,
АМГ-ын байр Уул уурхай, судалгааны хэлтэс

Утас: 976-11-263709

Факс: 976-11-310041

E-mail: navchaa68@yahoo.com

Web page: <http://www.mram.gov.mn>

АГУУЛГА

1. МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭЭ 4
2. МӨНГӨНИЙ ҮНИЙН БАЙДАЛ 2010 4
3. ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ОЛБОРЛОЛТ 6
4. МӨНГӨНИЙ ШИНЭЭР АШИГЛАЛТАНД
ОРОХ УУРХАЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ 9
5. ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭЭ 11
6. МӨНГӨНИЙ ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ 12
7. МОНГОЛ УЛСЫН МӨНГӨНИЙ НӨӨЦ БА
ГОЛ ОРДУУДЫН ТУХАЙ 13
8. АМГ-МӨНГӨНИЙ ҮНИЙН
ХЭТИЙН ТӨЛӨВ 14
9. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ 15





1. МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭЭ

Үйлдвэрлэл: Мөнгө нь бүх металл дотроос хамгийн сайн цахилгаан ба дулаан дамжуулагч металл бөгөөд иймээс олон төрлийн цахилгаан хэрэгсэлд, ялангуяа дамжуулагч, унтраагуур, холболт, гал хамгаалагч зэрэгт ашигладаг. Холболт нь 2 дамжуулагчийг хооронд нь холбож цахилгаан гүйдлийг салгаж, дамжуулдаг ба энэ нь цахилгааны хэрэглээнд хамгийн их хувийг эзэлдэг. Электрон барааны салбарын мөнгөний хамгийн ач холбогдол бүхий хэрэглээ нь: зузаан плёнкны түрхлэг, олон давхаргатай керамик конденсатор, мембран унтраалгын үйлдвэрлэл, цахилгаанаар халдаг автомашины шилний мөнгөлөг хальс, цахилгаан дамжуулах материал зэргийг үйлдвэрлэхэд оршдог. Фото зургийг гальваник иж бүрдлийн үйлдвэрлэл дэх мөнгөний хэрэглээ богино буюу дунд хугацаанд хурдан нэмэгдэх салбар болохоор харагдаж байна. Мөнгө хэрэглэдэг бусад үйлдвэрлэлд компакт диск ба дижитал видео диск, толь ба шил зэргийн гадар будагны материалын, мөн целлофан ба батерейний үйлдвэрлэл ордог байна.

Гоёл чимэглэл ба мөнгөн эдлэл: Мөнгө нь тусган ойлгох өндөр чадвартай, ямар ч металлаас илүү гялалзан өнгө ордог тул алттай адил ажлын гүйцэтгэлийг бий болгодог. Ийм учраас мөнгөний дархчуудын зорилго нь үргэлж мөнгөний угийн тод өнгөлөг гадаргуу дээр гэрлийг нэмэгдүүлэх ажил байдаг. 999-н сорьцтой цэвэр мөнгө нь амар зэвэрдэггүй, гоёл чимэглэлийг хийхэд бат бөх болгодог ба голдуу бага хэмжээний зэстэй хамт хольж хэрэглэдэг. Мөн алтны хайлш хийхэд мөнгийг үнэт металлуудтай хамт өргөнөөр хэрэглэдэг. 925-н сорьцтой мөнгө нь 14-р зууны үеэс эхлэн мөнгөн эдлэлийн стандарт болсон ба ялангуяа сав суулга, хоолны хэрэгсэл хийхэд ашигладаг байсан. Мөнгөөр бүрсэн мөнгөн эдлэлийн гадаргуу нь 20-30 микрон байхад гоёл чимэглэлийг мөнгөлөхөд 3-5 микрон болдог байна.

Гэрэл зургийн салбар: Гэрэл зургийн үйл ажиллагаа нь бромт кали юмуу натри хлорид гэх мэт уусамтгай шүлтлийн металлын галидтай голдуу азот хүчлийн мөнгө, уусамтгай мөнгөний уусмалыг хольж бэлтгэдэг гэрэл мэдрэмтгий мөнгөний галидын талстын оролцоон дээр суурилдаг. Гэрэл зургийн хальсыг рентген зураг авах, дүрслэх урлаг болон өргөн хэрэглээний гэрэл зургийн салбарт ихээр хэрэглэдэг. Гэрэл зургийн үйлдвэрлэгчдэд маш цэвэр мөнгө хэрэгцээтэй байдаг.

Зоосны хэрэглээ: Түүхээс харахад зоос цутгалтанд мөнгө нь алтнаас илүү өргөн хэрэглэгддэг байсан ба мөнгө ихээр нийлүүлэгддэг мөн бага үнэтэй байснаар өдөр тутмын төлбөрт ихээр хэрэглэгддэг байсан. 19-р зууны сүүлч хүртэл ихэнх үндэстнүүд мөнгөний стандарт дээр мөнгөн зоосыг гол төлбөрийн нэгж болгон ашигладаг байсан. Гэвч алтны хойноос хөөцөлдөж эхэлснээс хойш мөнгөний стандарт алтанд замаа тавьж өгөх нь нэмэгдсэн. Мөнгийг зоос цутгалтанд хэрэглэх нь аажмаар багассан ч Хөрөнгө оруулагчдад зориулсан зарим эргэлтэнд ордог зоосыг Америк, Австрали, Канад, Мексик Австри зэрэг орнуудад одоо хүртэл хэрэглэж байна.


2. МӨНГӨНИЙ ҮНИЙН БАЙДАЛ

Дэлхийн санхүүгийн зах зээл дээр үргэлжилж буй тодорхойгүй байдал нь хөрөнгө оруулагчдыг найдвартай хөрөнгө оруулалт хайхад хүргэснээр алт болон мөнгөний үнийн дээд хэмжээ тогтооход хүргэж байна. 2008 оны 12 сард 79:1 байсан мөнгө/алтны харьцаа 2010 оны 12 сар гэхэд 50:1 болсон.

Одоогийн үнийн байдал


Сомех биржийн бэлэн зарагдах мөнгөний дундаж үнэ 2008 онд 14,96 ам.доллар/унци байсан бол 2009 онд 14,67 ам.доллар/унци болж бага зэрэг буурсан байна. Дэлхийн эдийн засгийн хямрал гүнзгийрэхэд 2008 оны сүүлч, 2009 оны эхэнд 10-14 ам.доллар/унци байсан мөнгөний үнэ нэмэгдэж эхэлсэн.

Зураг 1



2010 оны 2-р сард 15,90 ам.доллар/унци байсан мөнгөний үнэ 6 сард 18,49 ам.доллар/унци болон нэмэгдсэнээр 2010 оны эхний хагаст мөнгөний дундаж үнэ 17,63 ам.доллар/унцид хүрсэн. 2-р зурагт үзүүлсний дагуу 2010 оны эхний хагаст мөнгөний алттай харьцуулсан үнэлгээ 65:1 байсан бол 2010 оны 2-р хагаст 55:1 болж дээшилсэн байна.

Зураг 2



2010 оны 7-р сард АНУ-ийн доллар чангарахад 6 сарын үнээс 3%-р бууж 17,89 ам.доллар/унци болж мөнгөний үнэ бага зэрэг буурсан байна. 8-р сарын сүүлчээр алтны үнэ хамгийн өндөр хэмжээнд хүрч алтны оронд зарим хөрөнгө оруулагчид мөнгийг худалдан авч эхэлсний дараа мөнгө/алтны харьцаа 67:1 хүртлээ буурсан. Мөнгөний үнэ 7 сарын алдагдлаа эргэж сэргээн дундаж үнэ нь 18,44 ам.доллар/унци болсон байна.

9 сард iShares Silver Trust (SLV) компаний нотолсноор мөнгөний худалдан авалт цаашид үргэлжилснээр мөнгөний үнийг 20 ам.доллар/унци-с дээш гаргасан нь 1980 оноос хойшхи анхны тохиолдол байлаа. Мөнгөний дундаж үнэ 20,61 ам.доллар/унци болсон нь 8-р сарын үнээс бараг 12%-р илүү байсан. 10-р сард мөнгөний үнэ дахин 14%-р өссөн ба үүнд Европын ерийн хямрал үргэлжилж долларын ханшыг сулруулж байсан нь нөлөөлсөн. 10 сарын дунд үеэр мөнгөний үнэ 24,90 ам.доллар/унцид хүрч 30 жилийн хугацааны хамгийн өндөр үнэд хүрсэн. Энэ сарын мөнгөний дундаж үнэ 23,90 ам.доллар/унци байсан. 2010 оны 11 сарын мөнгөний дундаж үнэ 26,60 ам.доллар/унци байгааг 2009 оны 11 сарын дундаж үнэтэй харьцуулахад 49%-р нэмэгдсэн

байна. 2010 оны эхний 11 сарын мөнгөний дундаж үнэ 19,43 ам.доллар/унци байгаа нь 2009 оны эхний 11 сарын дундаж үнэ 14,67 ам.доллар/унцитай харьцуулахад 32%-р нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

2011 оны 1-р сард эдийн засгийн тодорхой бус байдал үргэлжилж, алтны үнэ өндөр байсны нөлөөгөөр Мөнгө олборлолтонд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэх нь үргэлжилж, мөнгөний үнэ алтны үнийн нөлөөгөөр үргэлжлэн нэмэгдэж байсан.

3. ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ОЛБОРЛОЛТ

- 2010 онд дэлхий нийтийн мөнгөний олборлолт шинэ амжилтанд хүрч 735,9 сая/унци (22889тн)-д хүрсэн.
- Өнгөрсөн жил Орос улсын борлуулалт нэмэгдсэний үр дүнд цэвэр Засгийн газрын худалдааны хэмжээ 44,8 сая/унци (1393тн)-д хүрч нэмэгдсэн.
- 2010 онд үйлдвэрлэлийн болон гоёл чимэглэлийн дахин боловсруулалт ололттой байснаар хаягдал ашиглалт 14%-р өссөн.

2010 онд Дэлхий нийтийн мөнгөний олборлох үйлдвэрлэл 17,6 сая/унци (548 тн)-р нэмэгдсэний дараа 735,9 сая/унци (22889тн)-д хүрч 8 дахь жилдээ дараалан шинэ амжилт тогтоосон. Улсуудын хувьд авч үзэхэд Мексикийн Palmarejo – мөнгөний анхдагч ордын бүтээгдэхүүний өсөлт ба Pemasquito-цайрын сульфидийн ордын үйл ажиллагаа эхэлснээр 13%-ийн өсөлтийг дангаараа бий болгосноор Мексик улс нь дэлхийн хамгийн том үйлдвэрлэгчийн байр сууринд дахин очиж байна. Үүнтэй адилаар 2010 онд Аргентиний 20% өсөлтөнд Pirguitas –анхдагч мөнгөний ордын 1 жилийн ашигтай олборлолт чухал нөлөө үзүүлсэн байна. Хятад болон Австралид мөнгөний олборлолт нилээд өссөн гэж мэдээлсэн ба үүнд дэлхийн тэргүүлэх мөнгөний орд Cannington-ы үр дүнтэй олборлолттой энэ өсөлт холбоотой байна.

Дээрхи ололтыг бууруулсан том хэмжээний алдагдал Перуд -7,4 сая/унци (231тн) ба Орост- 5.4 сая/унци (167 тн) –д хүрсэн байна. Улсынхаа нилээд хэдэн том уурхайн ашиглалтын төлөвлөгөөнд тохиромжгүй асуудал нилээд оруулсан нь Перугийн мөнгөний олборлолтын үр дүнд нөлөөлсөн бол өнгөт металлын салбараас мөнгийг бага хэмжээнд олборлосон нь Оросын мөнгөний олборлосон хэмжээг буурахад нөлөөлсөн.

Мөнгийг бусад металлтай хамт үүссэн холимог ордоос бас олборлодог. Хар тугалга болон цайрын ордоос гарган авсан мөнгөний хэмжээ 5%-р өссөн байхад алт ба зэсийн салбараас гарсан үр дүн тус бүр 4% болон 1%-р буурсан үзүүлэлттэй байна.

Анхдагч мөнгөний уурхайн бүтээгдэхүүн 5%-р нэмэгдэж ба 2010 онд олборлосон нийт бүтээгдэхүүний 30%-ийг нийлүүлсэн байна.

Өнгөрсөн жил цэвэр үйлдвэрлэгчийн хеджинг рүү буцаж орсноор 61,1 сая/унци (1901тн) мөнгийг үйлдвэрлэж гаргаж авсан. Өнгөрсөн жил хамгийн үр дүнтэй үйл ажиллагаа нь олон талт үйлдвэрлэгч Minera Frisco компаниас гарсан ба үүнийг даган Barrick Gold ба Minera Volcan хеджингийн үйл ажиллагааг дэмжиж ажилласан. Эргээр 3 компаниуд хамтаараа 2010 онд гэрээгээр бараг 60 сая/унци (1866тн) нэмж олборлосон.

-3 жил дараалан буурсны дараа 2010 онд засгийн газрын худалдаа урьд жилийнхтэй харьцуулахад 29,3 сая/унци (910тн)-р нэмэгдэж 44,8 сая/унци (1393 тн)-д хүрч их өссөн. Энэ өсөлтөнд Оросын худалдан авалтын өсөлт чухал нөлөө үзүүлсэн байна.

Өнгөрсөн жил мөнгөний дахин ашиглалт 215,0 сая/унци (6687тн)-д хүрч шинэ амжилт тогтоон 14%-р өссөн байна.

Мөнгөний нийт нийлүүлэлт – Түүний бүрэлдэхүүн

Уул уурхайн үйлдвэрлэл мөнгөний нийлүүлэлтийн хамгийн том бүрэлдэхүүн хэсэг болох нь хэвээрээ байгаа ба хэвийн үедээ нийт нийлүүлэлтийн 2/3-г олборлож гаргадаг бол өнгөрсөн жил



нилээд өндөр хэмжээ болох 70%-д хүрсэн байна. Гэсэн ч уурхайн үйлдвэрлэл мөнгөний ганцхан эх сурвалж биш бөгөөд бусад эх сурвалжид хаягдал мөнгө, хөрөнгө оруулалтаа багасгах, засгийн газрын худалдаа ба үйлдвэрлэгчийн хеджинг ордог. Хаягдал буюу илүү зохимжтойгоор “хуучин хаягдал” гэдэг нь мөнгөөр үйлдвэрлэсэн эд зүйлс шинэчлэгдэн зах зээл рүү буцаж ирж байгаа мөнгийг хэлж байна. Эдгээр нь хуучин гоёл чимэглэл, гэрэл зургийн салбарт хэрэглэдэг химийн бодисууд, бүр хаягдсан компьютер зэргийг ч хамардаг байна.

Мөнгөний олборлолт

Географикийн хувьд уурхайгаас олборлосон мөнгөний талаас илүү хувийг Америк тивээс нийлүүлж байна. Үнэндээ том үйлдвэрлэгч 10 орны 6 нь Мексик болон Перу гэсэн хамгийн том үйлдвэрлэгч 2 орныг багтаан энэ бүс нутагт оршиж байна. Мөнгийг олборлож байгаа уурхайн төрөл нь зах зээлд хамгийн их хамааралтай байдаг ба ихэнх мөнгө нь бусад металлын уурхайгаас дайвар бүтээгдэхүүн болон гарч ирж байна. Ихэнх мөнгөний үйлдвэрлэлийг хар тугалга/цайр олборлох үйл ажиллагаанаас нийлүүлж байна.

Нийт олборлолтын 30% -г мөнгө өөрөө орлогын нь гол эх үүсвэр нь байдаг Анхдагч мөнгөний уурхайгаас нийлүүлж байна. Мөнгөний үнийн нөлөөлөл Анхдагч мөнгөний ордын бүтээгдэхүүн дээр ихээр нөлөөлдөг ба харин дайвар бүтээгдэхүүн болох мөнгөний олборлолт нь мөнгөтэй хамт олборлосон бусад металлын үнийн байдалд нөлөөлдөг гэдгийг тэмдэглүүштэй.


GFMS-ийн бэлтгэсэн Мөнгөний институтын Дэлхийн Мөнгөний Судалгаа 2009-д дурдсанаар 2009 онд олборлосон мөнгөний бүтээгдэхүүн 709,6 сая унцид хүрч 2008 оныхоос 3,6%-р өссөн байна.

2010 онд, Мөнгөний институтын мэдээ нь өнгөт ба үнэт металлын өндөр үнэ мөнгөний олборлолтыг 730,9 сая унцид хүргэж 3%-р нэмэгдүүлнэ гэж онцлон тэмдэглэсэн ба үүн дээр мөнгөний хаягдлыг дахин боловсруулсан хэмжээ ба дээр нь албан ёсны салбарын худалдаа нэмэгдэнэ.

Хүснэгт 1: Дэлхийн олборлосон мөнгөний бүтээгдэхүүн, 2003-2010

	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2009/2010
Андагч мөнгө	173.2	165.7	179	161.4	194.1	191.2	213.9	219.3	2.50%
Дайвар бүтээгдэхүүн	423.4	447.3	458.1	479.9	470.1	493.5	495.7	511.6	3.20%
Нийт олборлосон мөнгө	596.6	613	637.1	641.3	664.2	684.7	709.6	730.9	3%

Зураг 3



MEG-ийн MineSearch мэдээллийн бааз 2010 онд олборлолт явуулж 35 сая унци мөнгийг шинээр үйлдвэрлэсэн, ач холбогдол бүхий 7 уурхай ба ажиллаж байсан уурхай дахь өргөтгөлийн ажлын жагсаалтыг гаргасан.

Хүснэгт 2: Шинээр олборлолт явуулах мөнгөний уурхай ба өргөтгөлийн ажлууд

Уурхай	Эзэмшигч	Анхдагч металл	Байрлал	Төслийн байдал	Зардал (сая/доллар)	Хэрэгжих хугацаа	Нэмж олборлох бүтээгдэхүүн/унци/жил
Colquijirca	Minera El Brocal	Цайр	Перу	Өргөтгөл	200.0\$	2011	14.000.000
El Saucito	Fresnillo	Мөнгө	Мексик	Олборлолтын өмнөх	309.0\$	2011	9.000.000
Cerro de Pasco	Wolcan	Цайр	Перу	Өргөтгөл	200.0\$	2011	6.700.000
Goltsovoye	Polymetal	Мөнгө	Орос	Олборлолтын өмнөх	92.7\$	2010	6.400.000
El Porvenir	Minera Milpo	Цайр	Перу	Өргөтгөл		2011	5.250.000
Wolverine	Jinduicheng Molybdenum	Цайр	Канад	Олборлолтын өмнөх	250.0\$	2010	4.933.200
Santa Ana	Bear Creek Mining	Мөнгө	Перу	ТЭЗҮ	68.8\$	2012	4.600.000
Antamina	BHP Billiton, Xstrata, Teck Resources, Mitsubishi Corp	Зэс	Перу	Өргөтгөл	1290.0\$	2011	4.500.000
Cerro Bayo	Mandalay Resources	Мөнгө	Чили	Олборлолтын өмнөх	6.0\$	2011	3.000.000
Martabe	G-Resources, Gov't Indonesia	Алт	Индонези	Олборлолтын өмнөх	440.0\$	2011	3.000.000
Нийт					2856.5\$		61.383.200

2-р хүснэгтэд нарийвчлан үзүүлсний дагуу Goldcorp's Penasquito-ийн Мексик, Zacatecas дах полиметаллын ордоос жилд 28 сая унци буюу 80%-ийн хүчин чадлаар мөнгө үйлдвэрлэнэ гэж тооцож байна. Goldcorp нь 2010 оны 9 сард Penasquito-д худалдааны бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн ба 2011 оны эхээр уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллана гэж үзэж байна. Мексикийн Coahuila дах La encantada уурхайн First Majestic-ийн өргөтгөлийн ажил нь жагсаалтанд ганцхан байгаа Анхдагч мөнгөний орд юм. 2010 оны 4 сард, La encantada нь бүрээ хүчин чадлаараа ажиллавал жилд 4 сая унци мөнгө үйлдвэрлэх хүчин чадалтай, өдөрт 3500 м/тн-ыг цианидын аргаар баяжуулах үйлдвэртээ бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн. 2009 онд La encanta нь 1,32 сая унци мөнгө ба 1155 м/тн хар тугалга үйлдвэрлэсэн.

2010 онд Мөнгө олборлолтоор тэргүүлсэн 20 улс		
(тонн)		
1	Мексик	3,999.5
2	Перу	3,610.7
3	Хятад	3,085.1
4	Австрали	1,862.9
5	Чили	1,275.1
6	Боливи	1,275.1
7	АНУ	1,200.5
8	Польш	1,172.5

2010 онд Мөнгө олборлолтоор тэргүүлсэн 20 компани			
(тонн)			
Компани	Улс	Олборлолт	
1	Би Эйч Би Биллитон	Австрали	1,449.3
2	Фреснилло	Мексик	1,200.5
3	Кей Жи Эйч Эм Полска Миелз	Польш	1,160.0
4	Пан Американ Силвер Корп.	Канад	755.7
5	Гоулдкорп Инк.	Канад	715.3
6	Сиа. Минера Волкан	Перу	622.0
7	Хочсчайлд Майнинг	Перу	553.6
8	Жей Эс Си Полиметал	Орос	538.0
9	Коеур Д Алэн Майнз Корп.	АНУ	522.5

9	Орос	1,144.5
10	Аргентин	640.7
11	Канад	559.8
12	Казакстан	547.4
13	Турк	382.5
14	Марокко	301.7
15	Энэтхэг	301.7
16	Швед	286.1
17	Индонез	214.6
18	Гуатемала	195.9
19	Иран	105.7
20	ӨАБНУ	87.1

10	Сумитоно Корп.	Боливи	447.8
11	Казакмыс	Казакстан	438.5
12	Сиа. Де Майназ Бюнавентура	Перу	419.9
13	Саутерн Коппер Корп.	АНУ	391.9
14	Экстрата Зинк	Швейцар	360.8
15	Тек Ресурсэз	Канад	357.7
16	Ити Гүмүш А.Ш.	Турк	357.7
17	Кинросс Гоулд	Канад	351.4
18	Хекла Майнинг	АНУ	329.7
19	Яамана Гоулд	Канад	311.0
20	Индастриас Пеколез	Мексик	286.1

2010 онд дэлхийд тэргүүлэгч Мөнгөний уурхай


(тонн)

№	Уурхай	Улс	Олборлогч компани	Бүт.
1	Каннингтон	Австрали	Би Эйч Би Биллитон	1,200.5
2	Фреснилло	Мексик	Фреснилло	1,116.8
3	Гүмүшк	Турк	Ити Гүмүш А.Ш.	356.4
4	Дукат	Орос	Жей Эс Си Полиметал	345.2
5	Палланката	Перу	Хочсчайлд Майнинг / Интернейшнл Минаралз	315.4
6	Учучкакуа	Перу	Сиа. Де Майназ Бюнавентура	288.3
7	Арката	Перу	Хочсчайлд Майнинг	251.9
8	Грийнс Грек	АНУ	Хекла Майнинг	224.2
9	Имитер	Марокко	Сосиети Металлуржик димитер	223.9
10	Сан Балтоломе	Боливи	Коеур Д Ален Майнз Корп.	208.7
11	Аламо Дорало	Мексик	Пан Американ Силвер Корп.	207.7
12	Пиркюитас	Аргентин	Силвер Стандарт	195.9
13	Палмарижо	Мексик	Коеур Д Ален Майнз Корп.	183.2
14	Сан Хозе	Аргентин	Хочсчайлд Майнинг / Минера Андез	165.5
15	Ин	Хятад	Силверкоп Металз	134.4

4. МӨНГӨНИЙ ШИНЭ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ, 2010–2012

MEG-ийн MineSearch мэдээллийн бааз нь жилд 1 сая унци мөнгө үйлдвэрлэх хүчин чадалтай 5 төслийн жагсаалтыг гаргасан ба эдгээр нь 2010 онд үйлвэрлэлээ эхлэх буюу оны үлдсэн хэсэгт бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр төсөл нийт 200,7 сая унци сая унци мөнгө агуулж буй ашигт малтмал болон нөөцөөс жилд 17,2 сая унци бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай болно. 2011 онд нийт 56 сая унци мөнгөний бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай 12 төсөл буюу өргөтгөлийн ажил эхлэхээр төлөвлөсөн. Сүүлийн шатны нэмэлт 8 төсөл ба өргөтгөлийн ажил 2012 оноос эхлэх ба 554,2 сая унци нөөц агуулж буй ашигт малтмалаас жилд 16,3 сая унци бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай байх юм. 2010 оны сүүлч, 2011, 2012 онд эхлэх 25 төслийн 67%-ийг шинээр 89,5 сая унци мөнгө үйлдвэрлэх хүчин чадалтай Латин Америк, Хойд Америк 11%, Хуучин ЗХУ-ын орнууд 10%, Австрали 5%, Африк 3,2% ба Номхон далайн бүс нутгийн орнууд 3%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 4



4-р зурагт эдгээр Мөнгөний нөөцийн тархалт ба шинээр мөнгө олборлох төслүүдийн хүчин чадлыг байршлаар нь үзүүлж байна. Хамгийн том, шинээр мөнгө олборлох хүчин чадалтай үйлдвэрлэл Перуд Cerro de Pasco-с өмнө зүгт 10км байрлах Minera El Brocal-ийн эзэмшил Colquijirca полиметаллын орд дээр өргөтгөл хийснээр ирэх 2 жилд үйл ажиллагаагаа явуулж эхлэнэ. 200 сая долларын өртөгтэй өргөтгөлийн ажилд Tajo Norte уурхайг шинэчлэх ба хүдрийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх мөн Huaracasa баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн блох цайрыг жилд 180000 тн, хар тугалгыг жилд 70000тн, мөнгийг жилд 14 сая унци, зэсийг жилд 15000 тн-оор нэмэгдүүлэх ажлууд багтаж байна. Энэ өргөтгөлийн ажлын хүрээнд 47 сая тн ашигт малтмалыг олборлохоор төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр уурхай 2019 он хүртэл ажиллах боломжтой болох юм.

Дараагийн шинэ уурхай нь Мексикийн Zacatecas дахь El Saucito мөнгө-алтны уурхай орж байгаа ба 2011 оны эхний хагаст үйлдвэрлэлээ эхлэн жилд 45000 унци алт, 9 сая унци мөнгө олборлохоор төлөвлөж байна. 2009 оны сүүлчээр Saucito уурхайн бэлтгэл ажил дуусаж хүдэр олборлох ажил нь 2010 оны 3 сараас эхлэн явагдана.

Мөн тус бүр нь дэлхийн мөнгө үйлдвэрлэх хүчин чадлыг жилд доод тал нь 5 сая унци-р нэмэгдүүлэх хүчин чадалтай 3 өөр төсөл байна. Перу дэх цайрын үндсэн ордын 2 өргөтгөлийн ажил орж байна. Volcan-ны Cerro de Pasco уурхайд оксидын нөөцийг боловсруулах өргөтгөлийн ажил явагдаж байгаа ба өдөрт 2500 тн оксидын овоолгыг уусгах аргаар боловсруулах үйлдвэр барихаар төлөвлөсөн байна. 2 нэмэлт үйлдвэр байгуулснаар ойролцоогоор жилд 7,3 сая/унци мөнгө үйлдвэрлэж байгаа одоогийн хүчин чадлыг нэмэгдүүлж жилд 14 сая унци мөнгө үйлвэрлэх юм байна.

Үйлдвэрлэлийн өмнөх шатандаа байгаа дараагийн том төсөл нь Оросын Магадан дах Полиметаллын Goltsovoye төсөл юм. 2009 онд Goltsovoye уурхайд 52 г/тн агуулгатай 5000тн хүдэр олборлосон. 2011 оны эхээр олборлолтоо эхлүүлж Дукатын үйлдвэрт зарим хүдрээ баяжуулах зорилготойгоор Гүний уурхайн ажилаа эрчимжүүлсэн. 2008 оны 6-р сард Ovoca компани Goltsovoye уурхайн ТЭЗҮ-г танилцуулсан ба үүнд Хүдрийн 1-р бүсэд 6 жилийн хугацаанд жилд 260000 тн хүдрийг гүний уурхайгаас олборлоно гэж дурдсан. Хүдрийг баяжуулж Мөнгө болон хар тугалганы баяжмал гаргахдаа Гравитаци болон Флотацийн аргыг хослуулан хэрэглэнэ.

5. ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭЭ

Өнгөрсөн жил үйлдвэрлэлийн хэрэглээ 487,4 сая/унци (15160тн)-д хүрч 20,7%-р нэмэгдсэн. Энэ үр дүнд хүрэхэд тасралтгүй нэмэгдэж байгаа зах зээл дэх дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ба нийлүүлэлтээс дахин нөөцлөх зэргээр үйлдвэржилтийн өсөлт рүү буцаж орсон нь үүнд нөлөөлсөн. Эдгээр өсөлтөөс гэрэл зургийн гальваник, этилений ислийн катализатор ба автомашины үйлдвэрлэл гэх мэт ихэнх эцсийн бүтээгдэхүүн гаргадаг компаниуд нилээд ашиг олсон. Үйлдвэржсэн ертөнцийн барилгын салбарт хэрэглээ нилээд буурсан. Улсаар нь авч үзвэл Япон хэвийн байдалд буцаж орсноор хэрэглээ нь ихээр нэмэгдсэн ба нилээд хэмжээний хэрэглээний өсөлт Хятад, АНУ, Герман ба Өмнөд Солонгост бий болсон. Зөвхөн Энэтхэг улсад үнийн байдлаас шалтгаалж хэрэглээ нь буурсан.

Дэлхийн гоёл чимэглэлийн үйлдвэрлэл 2010 онд 167 сая/унци (5194 тн) –д хүрч 5,1%-р өссөн. Энэ өсөлтөнд хөгжиж буй олон зах зээл дээрхи дотоодын нийт бүтээгдэхүүний ололт нөлөөлсөн. Мөн мөнгөний гоёл чимэглэлийн зардал өсч аж үйлдвэржсэн орнуудад алтыг орлуулсан мөнгөний хэрэглээ их нэмэгдсэн. Мөнгөний өндөр үнэ хэрэглээг ямар нэг байдлаар багасгасан ч Энэтхэгийн зах зээлд ихээр нөлөөлсөн.

Өнгөрсөн жилд **мөнгөн эдлэлийн худалдаа** 50,3 сая/унци (1566тн) болж 14%-р буурсан. Ер нь энэ бууралт сүүлийн 10-д жил үргэлжилж байгаа ба 2009 онд бага зэргийн өсөлттэй байсан. Тусгаар тогтносон улсуудын хамтын нийгэмлэгийн орнууд болон Хятадаас бусад бүс нутаг бүрт бүтээгдэхүүн нь буурсан ба үүнд ихэнх барууны орнуудад удаан хугацаанд үргэлжилсэн бууралт мөн мөнгөний үнийн өсөлт нөлөөлсөн байна.

Гэрэл зургийн салбар дахь мөнгөний хэрэглээ 72,7 сая/унци (2261тн) болж 6,6 сая/унци (2261 тн) буюу 8,3%-р буурсан ба энэ нь сүүлийн 9 жилийн доторхи хамгийн бага алдагдал байсан. Үүнд уламжлалт рентген зургийн бүтээгдэхүүн дэх бага хэмжээний бууралт гол нөлөө үзүүлсэн.

Зоос цутгалтын ажил 101,3 сая/унци (3151 тн)-д хүрч 28%-р нэмэгдэж дээд амжилт тогтоосон. Европ ба АНУ-д мөнгөн зоосны жижиглэн худалдааны хөрөнгө оруулалтын хэрэглээн дэх гол өсөлт энэ дээд амжилтанд хүргэх гол хүчин зүйл байсан. Өнгөрсөн жилд Мөнгөн зоосны гол үйлдвэрлэгч болох АНУ-н Eagle, Канадын Maple Leaf, Австралийн Philhamoniker ба Kookaburra компаниуд зоос цутгалтаар дээд амжилт тогтоосон байна.


GFMS-ийн 21 жилийн мэдээллийн сангаас харахад 2010 онд баталгаат хөрөнгө оруулалтын хэмжээ 178 сая/унци (5537тн)-д хүрч 47%-р өссөн нь дээд амжилт тогтоосон. Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв сайжирсан хандлага бий болж мөнгөний үйлдвэрлэлийн хэлхээ холбоо буцаж бий болоход хөрөнгө оруулагчдын сонирхол бий болж эхэлсэн. Европын өрийн асуудлаас шалтгаалан бий болсон алтын зах зээл дэх өндөр амжилтын ачаар Мөнгөний үнэт байдлын баталгаа нь цаашид удаан хугацааны хөрөнгө оруулалтын урсгалыг бий болгосон.

Мөнгөний Институтын гаргасан Дэлхийн Мөнгөний Судалгаа 2010-т үзүүлснээр дэлхий нийтийн мөнгөний үйлдвэрлэлийн хэрэглээ 2009 онд 729,9 сая унци болж 12%-р буурсан ба үүнд аж үйлдвэрийн хэрэглээ 21%-р буурсан болон гэрэл зургийн хэрэглээн дэх бууралт үргэлжилж байсан нь нөлөөлсөн. Зоос болон медалийн хэрэглээ 21%-р ба гоёл чимэглэлийн хэрэглээ бага зэрэг өссөн байна.

Хүснэгт 4: Дэлхийн мөнгөний үйлдвэрлэлийн хэрэглээ, 2003-2010 (сая/унци)

	Аж үйлдвэр	Гэрэл зураг	Гоёл чимэглэл	Мөнгөн эдлэл	Зоос ба медаль
2003	349.7	192.9	179.2	83.9	35.7
2004	367.1	178.8	174.9	67.3	42.4
2005	405.1	160.3	173.8	67.8	40
2006	424.5	142.4	166.3	61.2	39.8
2007	453.5	124.8	163.5	58.8	39.7
2008	443.4	104.9	158.3	56.9	65.2
2009	352.2	82.9	156.6	59.5	78.7
2010	415.6	73.8	158.9	51.8	96.8

Зураг 5



4-р хүснэгт болон 5-р зурагт үзүүлснээр дижитал аппарат тогтмол нэмэгдэж байгаагаас шалтгаалан гэрэл зургийн салбар дахь мөнгөний хэрэглээний бууралт үргэлжилж байна. 2010 онд аж үйлдвэрийн болон зоосны өндөр хэрэглээний дүнд нийт мөнгөний үйлдвэрлэлийн хэрэглээ 9%-р нэмэгдэх хэтийн төлөвтэй байсан. 2009 онд мөнгөний нийлүүлэлт нь нийт үйлдвэрлэлийн хэрэглээнээс 145 сая унциар илүү гарч байсан ба 2010 онд дахин 100 сая унцийн илүүдэлтэй байхаар төлөвтэй байсан. Энэ нь үнийг буурахад нөлөөлж байсан.

6. МӨНГӨНИЙ ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

CIBC World Markets : 2010 онд Алтны үнэ 28%-р нэмэгдэж өндөр байгаатай уялдан мөнгөний үнийн өсөлт 64%-р нэмэгдсэн нь гайхамшигт үйл явдал байсан гэж дурдсан байна. CIBC, Mineweb's America –ийн эрхлэгч Dorothy Kosich алтны болон эдгээр металлын үндсэн байдлын хамааралтайгаар мөнгөний үнэ өснө гэж таамаглаж байна. CIBC нь Мөнгө Алттай адил үнийн гүйцэтгэл үзүүлэх болно гэж итгэж байна.

CIBC World Markets мөнгөний үнийг 2011 онд 28 ам.доллар/унци, 2012 онд 30 ам.доллар болно гэж үзэж байна.

GFMS: 11 сарын Interim Silver Market Review –д нийт мөнгөний нийлүүлэлтээс харахад 3 жилд тогтвортой байсан мөнгөний үнэ төгсгөл болж 2010 онд 5%-р нэмэгдэнэ гэж дурдсан. Уурхайн бүтээгдэхүүн 2010 онд 3%-р буюу 24 сая унциар нэмэгдэн даруухан өсөлтийг үзүүлнэ. Зэсийн уурхайнууд мөнгийг бага хэмжээгээр нийлүүлж байхад алт ба хар тугалга-цайрын үнэ тогтмол нэмэгдэж байгаатай уялдан Дэлхий нийтийн анхдагч мөнгөний бүтээгдэхүүн 3%-р өснө гэж тооцсон байна. Хаягдлын нийлүүлэлт нь 2010 оны мөнгөний нийлүүлэлтийг 10%-р өсгөх ба CIS (Тусгаар тогтносон улсуудын хамтын нийгэмлэг)-орнуудын их худалдааны нөлөөгөөр Засгийн газрын худалдааг ихээр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.

Хэрэглээний тал дээр GFMS нь 2010 онд нийт үйлдвэрлэлийн хэрэглээ хэдийгээр 2008 оны хэрэглээнээс 4%-р бага боловч бараг 10%-р өснө гэж үзсэн. 2011 оны бүтээгдэхүүний бага зэргийн өсөлт нь Дэлхийн мөнгөний хэрэглээг дээр үеийн түүхэн амжилтын хэмжээнд хүртэл нэмэгдүүлнэ.

GFMS нь хөрөнгө оруулалтын хэрэглээ /зоос болон медалийг оролцуулан/ нэмэгдсэн хэвээр байгаа ба 2010 онд мөнгөний олборлолтыг бүх цаг үеийн хамгийн их хэмжээ болох 2010 сая унциар нэмэгдүүлэх ба 2011 онд шинэ дээд амжилт тогтоохоор төлөвлөсөн гэж мэдээлсэн.

GFMS нь 2011 онд мөнгөний жилийн дундаж үнэ 28 ам.доллар/унци орчим байх ба үнэ нь 30 ам.доллар/унциас дээш гарна гэж үзэж байна.

BMO Capital Markets:

VM Group: 2010 оны 11 сарын ABN AMRO Metals Monthly Investment Research сэтгүүлдээ алтны үнийн 23%-ийн өсөлттэй харьцуулахад мөнгөний үнэ 50%-р нэмэгдсэнээр мөнгө нь 2010



онд хамгийн сайн гүйцэтгэлтэй бүтээгдэхүүний нэг байсан гэж тэмдэглэсэн байна. Үүний үр дүнд 2010 онд мөнгө/алтны үнийн харьцаа бууж 2 жилийн хамгийн доод хэмжээ болох 49:1-д хүрсэн. Мөнгөний биржээр зарагдсан нөөцийн өсөлт хөрөнгө оруулалтын хэрэглээг нэмэгдсэнийг тусгаж байна.

VM Group нь мөнгө/алтны харьцаа богино хугацаанд буурах ба 2011 онд мөнгөнийн дундаж үнэ 27,66 ам.доллар/унци, 2012 онд үнэ нь бууран 20 ам.доллар/унци болно гэж үзэж байна.

2010 оны 10 сард **Reuters** ба **International Business Times** нь нилээд хэдэн хөрөнгө оруулалтын банкнаас гаргасан үнийн таамаглалыг нийтэлсэн. 2010 оны дундаж үнэ 19,34 ам.доллар/унцитай харьцуулаад дунджаар адилтгаж болох 9 таамаглал нь 2011 онд мөнгөний үнэ дунджаар 21,97 ам.доллар/унци байна гэж үзсэн. Тэдний ихэнх нь үнийн урьдчилсан таамаглалаа нэмэгдүүлсэн.

Goldman Sachs: Мөнгөний үнийг 3 сарын дотор 23,40 ам.доллар/унци, 6 сарын хугацаанд 25,50 ам.доллар/унци, 12 сарын хугацаанд 27,60 ам.доллар/унци болно гэсэн таамаг гаргасан.

Citigroup: Богино ба дунд хугацааны мөнгөний үнийн урьдчилсан таамаглалаа 20 ам.доллар/унциас 25 ам.доллар/унци болгон нэмж мөнгө /алтны үнийн харьцаа нилээд тогтвортойгоор 58 байх болно гэж үзсэн.

Barclays Capital: Мөнгөний үнэ нэмэгдэн 2011 онд 22,20 ам.доллар/унци, 2012 онд дундаж үнэ 17 ам.доллар/тн болно гэж үзжээ.

Scotia Mocatta: 2011 онд мөнгө хамгийн ихдээ 27 ам.доллар/унциар худалдаалагдах ба 2012 онд бууран 17 ам.доллар/унци болно гэсэн урьдчилсан таамаглал гаргасан.

RBS Global Banking: 2010 оны 8 сард гаргасан мэдээлэлдээ 2011 онд мөнгөний дундаж үнэ 21,25 ам.доллар/унци хүртэл нэмэгдэнэ гэж мэдээлсэн. Мөн 2010-2014 оны хооронд мөнгөний хэрэглээний өсөлт нийлүүлэлтийн өсөлтөө аажмаар гүйцэж түрүүлнэ гэж тооцож байна.

BoA-Merrill Lynch: 2011 онд мөнгөний үнэ 20,25 ам.доллар/унци, 2012 онд 21 ам.доллар/унци болно гэж дурдсан.

Morgan Stanley: 2010 оны 10 сарын 5-нд гаргасан нийтлэлдээ 2011 онд мөнгөний үнэ нэмэгдэн 20,23 ам.доллар/унци болж 2012 онд бууран 19,53 ам.доллар/унци болно гэж дурджээ.

HSBC: 2011 оны мөнгөний үнийн урьдчилсан таамаглалаа 15,50 ам.доллар/унциас 20 ам.доллар/унци хүртэл, 2012 оны үнийг 15,25 ам.доллар/унциас 17,50 ам.доллар/унци хүртэл нэмсэн байна.

JPMorgan: 2010 оны 9 сарын 30-нд гаргасан мэдээлэлдээ 2011 онд мөнгөний дундаж үнэ 19,20 ам.доллар/унци байна гэж үзсэн.

7. МОНГОЛ УЛСЫН МӨНГӨНИЙ НӨӨЦ БА ГОЛ ОРДУУД

Манай улсын мөнгөний нөөц 2200 тонн байдаг бөгөөд прогнозын нөөц нь 6000 тонн байдаг. Гэвч энэ баталгаатай бус, нарийвчлан хайгуул хийсний дараа 50 хувь дээшлэх, доошлох магадлалтай аж. Одоо тогтоогдсон нөөцийг 550 сая долларар үнэлдэг байна.

Мөнгөний 75-80 хувийг мөнгө агуулсан зэс, хар тугалга, цайрын ордуудын хүдрийг боловсруулах явцад гаргаж авдаг байна. Үүнээс мөнгө байгаль дээр цэвэр байдлаар тохиолдох нь цөөн гэсэн дүгнэлт хийж болно. Алт-мөнгөний болон хар тугалга-мөнгөний ордоос 15-20 хувийг гарган авдаг бол, үлдсэнийг нь туслах төрөлд хамрагдах ордоос авдаг гэнэ лээ. Манай орны хувьд Хар толгой, Мөнгөн өндрийн ордууд хар тугалга мөнгөний төрөлд багтдаг бөгөөд Асгатын орд мөнгө суурьмагийн төрөлд багтдаг байна.

2011 оны 11 сарын 10-ны байдлаар Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн бүртгэлд мөнгөний 2 орд 222,31 мян.тн-н нийт нөөцтэйгөөр бүртгэгдсэн байна.

Оюу толгой төслийн үйл ажиллагаа нь эхлэхээр жилд 544000 тн зэс, 650000 унци алт, 3 сая унци мөнгө олборлох ба энэ үед манай улсын мөнгөний олборлолт нилээд нэмэгдэнэ гэж тооцож байна.

Асгатын мөнгөний орд

Монгол Улсын стратегийн гэх тодотголтой 15 ордын нэг нь Асгатын мөнгөний орд. Монголын баруун-хойд хэсэгт ОХУ-ын Горный-Алтай муж ба Тува Улстай хил залгаа Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт оршдог энэхүү орд нь өндөр уулын бүсэд уул-техникийн хүнд нөхцөлтэй, дэд бүтэц хөгжөөгүй алслагдсан газарт байрладаг шалтгаанаар 1970-аад онд нээснээс нь хойш өнөөг хүртэл ашиглагдаагүй юм.

Асгатын мөнгөний орд нь нөөцийг өнөөдрийн байдлаар нийт хүдрийн нөөц 6402600 тн ба мөнгөний хэмжээг 2247800 тн гэж тогтоосон байдаг. Үүнээс гадна висмут, сурьма, зэс мөн тодорхой хэмжээний алт, хар тугалга, төмрийн нөөцтэй гэж тогтоогдсон байна. Асгатын мөнгө нь үйлдвэрлэлийн зориулалттай гэдгээрээ бусад ордоос арай илүү үнэлэгддэг байна.

Мөнгөн өндөрийн мөнгө-холимог металлын орд

Энэ орд нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 310 км, Хэнтий аймгийн төвөөс баруун хойш 80 км, Өмнөдэлгэр сумын төвөөс зүүн тийш 30 км орчим зайд оршдог. Талбайн хэмжээ 231 га. Энэ холимог металлын орд дээр 1983-1992, мөн 2008-2009 онд “Голден хейлс” компани хайгуул хийсэн бөгөөд одоогийн байдлаар хүдрийн нөөц нь 2470000 тн ба мөнгөний нөөц нь 478000 тн гэж тогтоогдсон байна.


Мөнгө нь ижил төрлийн металлуудаас үнэ хямд гэдгээрээ өргөн хэрэглэгддэг бөгөөд үйлдвэрлэл нэмэгдэх тутам мөнгөний үнэ тэр хэрээр нэмэгдэх ба сүүлийн үед алтны үнэ их хэмжээгээр нэмэгдэж байгаа нь мөнгөний цаашдын үнийн өсөлтөнд гол нөлөө үзүүлэх хандлагатай байна.

8. АМГ-МӨНГӨНИЙ ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

2010 онд мөнгөний дундаж үнэ 20,19 ам.доллар/унци байсан бол 2011 онд 35,12 ам.доллар/унци болж 73%-р нэмэгдсэн. 2011 он гарсаар мөнгөний үнэ маш хурдацтай нэмэгдсээр 4 сард мөнгө үнийн дээд амжилт тогтоож 48,7 ам.доллар/унцид хүрсэн ба 5,6 сард бага зэрэг буурч 7-р сараас эхлэн алтны үнэтэй хамааралтайгаар дахин нэмэгдэж 40 ам.доллар/унциас илүү гарсан. 3,4-р улиралд үнэ нилээд буурсан ба Мөнгөний үнийн бууралтанд алт болон нийт өнгөт металлын үнийн бууралт, зах зээлийн тодорхойгүй нөхцөл зэрэг нь нөлөөлж байсан.

2012 оны 1-р улирлын мөнгөний дундаж үнэ 32,58 ам.доллар унци байгаа нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 2,9%-р нэмэгдсэн байна. Алтны үнийн адилаар дунд болон урт хугацаанд мөнгөний үнийг дахин нэмэгдэх хандлагатай гэж үзэж байна.

2011 он	Дундаж үнэ	Харьцуулалт	Өөрчлөлт
I ул.	31.66		
II ул.	38.14	II/I	20%
III ул.	38.78	III/II	2%
IV ул.	31.8	IV/III	-18%





Тойм ба хэтийн төлөв

Мөнгөний үнэ өнгөрсөн нэг жилийн дотор 78% өсч гайхмаар амжилттай байсан. Эрэлт хэрэгцээн дэхь 2 үндсэн өсөлт үүнд нөлөөлсөн.

Хөрөнгө оруулагчийн хувь хэмжээ ихээр өсч дэлхийн хөрөнгө оруулалтын хэмжээг 279,3 сая унци /8,689 тн/-д хүргэж бараг 40% өсөлтийг бий болгосон нь энэ орлогын гол хүчин зүйл байсан.

Үйлдвэрлэлийн хэрэгцээний өсөлт нь гол үйлдвэрийн салбарт сэргэлтийг бий болгосон ба энэ хоёрын тэнцвэр нь нийлүүлэлт нэмэгдсэнийг үзүүлсэн.

- 2010 оны Нийлүүлэлтийн байдлаас харахад нийт мөнгөний нийлүүлэлт 15%-р өсч 1,056.8 сая унцид /32870 т/ хүрсэн. Бүх салбарууд бодит өсөлтийг мэдээлж байсан ба энэ өсөлтөнд үйлдвэрлэгчийн хеджингийн орлого, засгийн газрын худалдаа ба мөнгийг дахин ашиглах үйл явц гол нөлөө үзүүлсэн.

Хар тугалга/цайрын салбар ба мөнгөний анхдагч ордоос нэмэгдсэн шинэ үйлдвэрлэлийн хүчин чадлын үр дүнд олборлох үйлдвэрлэл харьцангуй энгийн буюу 2,5% нэмэгдсэн хэдий ч энэ нь одоогийн байдлаар дээд хэмжээ болох 735,9 сая унци /22,889 тн/-д хүрсэн.

Өнгөрсөн жил нийт үйлдвэрлэл 878,8 сая/унци (27333 тн) –д хүрч 13%-р өссөн ба энэ нь 2000 оны дээд үзүүлэлтэнд ойртож очсон. Үйлдвэрлэлийн хэрэглээний 21%-ийн өсөлт нь энэ үр дүнд хүргэсэн гол хүчин зүйл байсан. Энэ хэрэглээний өсөлтийг гоёл чимэглэл ба зоосны худалдаа бүрдүүлж байсан ба сүүлийн үеийн бүртгэлээр 28%-ийн өсөлтийг тэмдэглэсэн байна. Эдгээр өсөлт нь мөнгөн эдлэл болон гэрэл зургийн салбарын үйл ажиллагааг бүтцийн алдагдалд ороход нөлөөлсөн.

- Хөрөнгө оруулалтын байдлыг авч үзэхэд өнгөрсөн жил баталгаат цэвэр хөрөнгө оруулалт бүх цаг үеийн хамгийн өндөр хэмжээ болох 178,0 сая/унци (5537тн)-д хүрч 47%-р нэмэгдсэн. Хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаа жилийн ихэнх хэсэгт харьцангуй тогтуун байсан ба сүүлийн 4 сар нилээд хэлбэлзсэн. Эдгээр саруудад хөрөнгө оруулалтын ихэнх хэсэг нь Хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг сан болон (ETF), биржийн бус зах зээл (OTC) ба биет гулуузаар борлуулахад харин бага хэсэг нь Comex бирж дээр тус тус зарцуулагдсан байна.

Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв сайжрахад мөнгөний үйлдвэрлэлийн хэрэгцээнд сонирхол татсан байдал ихээр бий болсны дараа хөрөнгө оруулагчид Европын өрийг хамарсан асуудал ба АНУ, Япон дахь цаашдын эдийн засгийн сэргэлт буцаж бий болоход цагаан металлыг найдвартай хөрөнгө гэж үзэх болсон.

Хэтийн төлөвийг авч үзэхэд 2012 онд мөнгөний бодлого их хэмжээгээр чангарах байдал харагдахгүй байгаа тул хөрөнгө оруулалтанд шаардагдах эдийн засгийн ерөнхий байдал нааштай хэвээрээ байх ба үйлдвэрлэлийн хэрэглээ нэмэгдэж байгаа нь үнийн байдалд нэмэлт дэмжлэгийг бий болгоно гэж үзэж байна. Мөнгөний дундаж үнэ 2012 онд 33-35 ам.доллар/унци, 2013 онд 35-40 ам.доллар/унци байх хандлагатай байна.

9. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Ашигласан материал:

Metals Economics Group

<http://www.metalseconomics.com/>

GFMS

<http://www.gfms.co.uk/>

Kitco

<http://www.kitco.com/>

The Silver Institute

<http://www.silverinstitute.org>

Монгол банк

<http://www.mongolbank.mn/>

